

ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ

ТЭМДЭГЛЭЛИЙН

ДЭВТЭР

ЧУУЛГАН
АЙСУЙ!

ГЭРЧЛЭЛЭЭ ХҮЧИРХЭГЖҮҮЛЖ,
ЕСҮС ХРИСТЭД ОЙРТОЖ, ХУВИЙН
ИЛЧЛЭЛТЭЭ ХҮЛЭЭН АВАХ ЦАГ БОЛЖЭЭ.

"... Би энэхүү чуулган бүх хүний хувьд сүнслэг хүч чадлаа сэлбэх цаг байгаасай хэмээн залбирсан. ... Энэ чуулган та нарын хувьд амар амгалан цаг, сүнслэг байдлын хувьд найрлах цаг байх болтугай. Та нар эдгээр хуралдааны үеэр хувийн илчлэлт авахаар эрэлхийлж мөн хүлээн авах болтугай."

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

АСУУ,

“Зүрх сэтгэлдээ байгаа асуултууддаа цэвэр илчлэлт хүлээн авах нь энэ чуулганыг үнэ цэнтэй бөгөөд мартагдашгүй болгох болно.”

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон²

ТЭГЭЭД СОНС

Чиний оюун бодолд яг одоо асуулт эсвэл санааг чинь зовоож буй зүйл байна уу? Магадгүй чамайг өргөж, урамшуулах сайн найзуудыг хайж олох тухайд санаа чинь зовж байж болно. Өөрийгөө үнэлэх үнэлэмжээ хэрхэн дээшлүүлэх эсвэл бурханлаг мөн чанараа хэрхэн санах вэ гэж гайхширч бас болно. Магадгүй чи аль их сургуульд элсэхээ шийдэх гэж оролдож байгаа байх. Эсвэл чи маш их зөрчилдөөн, уур хилэнгээр дүүрсэн дэлхий дээрх ирээдүйн талаар ерөнхийд нь санаа зовж байж магадгүй юм.

Би яаж өөртөө илүү дуртай болох вэ?

Би яаж ирээдүйдээ санаа зовохоо багасгах вэ?

Би боловсролоо хэрхэн, хаана үргэлжлүүлэх ёстой вэ?

Би яаж сайн найзуудтай болох вэ?



ЧАМД ЮУ БОДОГДОЖ БАЙНА ВЭ?

Хэрэв чи асуулт, санаа зовоож буй асуудлуудаа оюундаа хадгалсаар байвал Ерөнхий чуулганаас илүү ихийг мэдэж авна. Чамайг зүрх сэтгэлээ нээж, Түүний үйлчлэгчдийг сонсох үед Их Эзэн хариултаа олоход чинь туслах болно.



Асуултууд:



Хариултууд:



“Бурхан үнэхээр бидний хүн нэг бүртэй байгуулсан гэрээ, амлалтууддаа хүндэтгэлтэй хандах болно. Үүнд бид санаа зовох шаардлагагүй. . . . Бид хамгийн сайнаараа үйлдээд, материаллаг болон сүнслэг адислалуудын зохицуулалтыг Түүнд даатгах учиртай.”

Ахлагч Д.Тодд Кристоффэрсон³

СЭДВЭЭР СУРАЛЦАХ

Чи сонссон үгээсээ ямар нэг сэдвийг олсон уу? Яг одоо чиний хувьд чухал ямар зүйл байна вэ?

Сэдэв:

Энэ нь миний хувьд ямар утгатай талаар:



БИЧИХ ДУРГУЙ ЮУ?

Хэн ч чамайг чуулганы тэмдэглэлээ бичих ёстой гэж хэлээгүй. Хэрэв зурах нь бодол санаагаа илүү сайн буулгахад тусалдаг бол бичихийн оронд зурж болно. Өөртөө тохирох зүйлийг хий.

НАДАД ТӨРСӨН МЭДРЭМЖ, СЭТГЭГДЭЛ





“Түүнийг Сонс’ гэх хоёр үгэнд Бурхан энэ амьдралд амжилт, аз жаргал, баяр баясгаланг олж авах загварыг өгчээ. Бид Их Эзэний үгийг сонсож, анхаарч, бидэнд хандан хэлсэн зүйлсийг нь дагах ёстой.”

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон⁴



ТААЛАГДСАН ҮГ

Чамд энэ чуулганаар сонссон үгсээс таалагдсан үг бий юу? Үг хэлэгчдийн нэр, юуны тухай, яагаад чамд маш их таалагдсан тухай бичихийг бод.

ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ ЦАГ

Чуулган дуусмагц, сонссон, мэдэрсэн зүйл дээрээ ажиллах цаг ирнэ. Эхлэхэд чинь туслах хэдэн асуултыг өгье.

- Ирэх өдрүүдэд би нэг зүйл дээр төвлөрье гэвэл юун дээр төвлөрч болох вэ?
- Амьдралдаа өөрчлөх хэрэгтэй ямар нэгэн зүйл надад бий юу?
- Би амьд бошиглогчдын тухай гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлэх вэ?
- Аврагчийг хайрлах миний хайр хэрхэн өсөж болох вэ?
- Өдөр тутмын амьдралдаа Түүнийг илүү сайн сонсохын тулд хийж чадах зүйл надад бий юу?
- Чамд байгаа бусад асуулт:



“Тийм ээ, бид өнгөрснөөсөө суралцаж чадна, суралцах ч хэрэгтэй. Тийм ээ, бид ирээдүйдээ бэлдэж чадна, бэлдэх ч хэрэгтэй. Гэхдээ зөвхөн *одоо* л бид хийж чадна. *Одоо* л бид суралцаж чадна. *Одоо* л бид наманчилж чадна. *Одоо* л бид бусдыг адисалж чадна.”

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон⁵

ЭХ СУРВАЛЖ

1. Рассэлл М.Нэлсон, “Амар амгалангийн сайн мэдээг номлох нь,” 2022 оны 4-р сарын Ерөнхий чуулган (*Лиахона*, 2022 оны 5-р сар, 6–7).
2. Рассэлл М.Нэлсон, “Цэвэр үнэн, цэвэр сургаал, цэвэр илчлэлт,” 2021 оны 10-р сарын Ерөнхий чуулган, (*Лиахона*, 2021 оны 11-р сар, 6).
3. Д.Тодд Кристоффэрсон, 2022 оны 4-р сарын Ерөнхий чуулган (*Лиахона*, 2022 оны 5-р сар, 78).
4. Рассэлл М.Нэлсон, “Түүнийг сонс,” 2020 оны 4-р сарын Ерөнхий чуулган.
5. Рассэлл М.Нэлсон, “Цаг нь ирлээ,” 2022 оны 4-р сарын Ерөнхий чуулган, (*Лиахона*, 2022 оны 5-р сар, 126).

© 2023, Intellectual Reserve, Inc.


Бүх эрх хамгаалагдсан.

Хувийн болон арилжааны бус хэрэгцээнд зориулан уг товхимлыг дахин хэвлэх зөвшөөрөл өгч болно. Тойргийн удирдагчид өөрсдийн дуудлагын хүрээнд үйлчилж буй хүмүүстээ зориулан цөөн тоогоор хэвлэх зөвшөөрөл өгөх нь үүнд багтана. Уг товхимлыг бүхэлд нь хэвлэх ёстой. Энэхүү зөвшөөрөл нь уг материалыг онлайн дээр байршуулах, өөр зорилгоор ашиглах, түгээхтэй хамааралгүй. Уг материалыг өөр зорилгоор ашиглах бол зөвшөөрөл авах шаардлагатай.

permissions.ChurchofJesusChrist.org

ӨӨР ИЛҮҮ ХУВЬ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Энэхүү тэмдэглэлийн дэвтрийг
conference.ChurchofJesusChrist.org
хаягаар орон, татан авч хэвлэнэ үү.



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ